



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/626

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр Бигэр сумд "Их Хайрханы Хаялага" ХХК-ны хийж гүйцэтгэсэн 5 га талбайд хийсэн ойн зурвас байгуулах ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л. Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Б. Цэрэнбал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Т.Лодой (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, аялал жуулчлал, захиргаа аж ахуй хэлтсийн дарга)

Ч. Лхагвадулам (Орон нутгийн өмчийн газрын хяналт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн)

Г. Мөнхбаяр (Бигэр сумын Засаг дарга)

М. Энхболд (Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

М. Гансүх (Бигэр сумын байгаль хамгаалагч)


Д. Эрдэнэдаваа ("Их хайрханы хаялага" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Б. Пүрэвдорж (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, ургамал, байгалийн гамшигийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.

2.Ойн зурвасыг хүлээн авч ашглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Л. Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа хамгаалалтыг хариуцаж ажиллахыг сумын Засаг даргад даалгасугай.

ОРЛОГЧ  Г. ЧИНБАТ